



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бугат сумын ТТЗ-ийн

2016 оны 12 дугаар сарын 31-нээр

дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2017/6/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Тэргүүлэх аудитор: М.Хуанган Цахим хуудас: 0

Утас: 99417382 Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 99932710 Цахим хаяг: kh_jenisbek@yahoo.com

Аудитор: Д.Назгүл

Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	Error! Bookmark not defined.
2.12	Шилэн дансны мэдээлэл	Error! Bookmark not defined.
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	15
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	15
3	Менежментийн захидал	Error! Bookmark not defined.
3.1	«management_zurchil1»	Error! Bookmark not defined.
3.2	«management_zurchil2»	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	17
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	17
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	19
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	23
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	27

1 Аудитын гэрчилгээ



БУГАТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Х.ХАЙВ ТАНАА

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий сум, Баян-Өлгий аймаг,
Утас/факс:(976) 7042-2954

E-mail:bayanulgi@audit.gov.mn

БТН. 02.01 № 14 БТН-2016/07-ТТЗ
танай _____-ны № _____-□

Аудитын гэрчилгээ

Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Баян-Өлгий аймгийн Аудитын газраас аудит хийв.

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулга материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Gershilgee.doc

Зөрчилгүй санал дүгнэлт

Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Бугат сумын Засаг дарга Х.Хайв танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Бугат сумын ТТЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Бугат сумын ТТЗ-ийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.03.05-наас 2017.03.20-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.03.20-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Аймгийн аудитын газрын аудитор Д.Назгүл хариуцаж хэрэгжүүлэв.

Бугат сумын ТТЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017.03.05-нд төрийн аудитын байгууллагад 2017.03.04-ны өдрийн 44–р албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Бугат сумын Засаг дарга *“Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, харьяалах нутаг дэвсгэрийнхээ санхүүгийн байдал, хүн амын орлого, хөдөлмөрийн нөөц, газрын төлөв байдлын удирдлага, төлөвлөлтийг хангахад шаардагдах тайлан тэнцэл гаргах,*

-харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан тайлан мэдээг хугацаанд нь хариуцан гаргуулж, хяналт тавих, хүн ам, орон сууц, газар, мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах, нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах” эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Бугат сумын ТТЗ-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Бугат сумын ТТЗ-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Бугат сумын ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Бугат сумын ТТЗ-ийн санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн "Пластик", "Акколоус" програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Бугат сумын ТТЗ-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулья.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 17 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 6 асуудал эрсдэл өндөр, 4 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-В-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 30 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 6 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгов.

Нийт хөрөнгийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд нийт хөрөнгийг сонгож төлөвлөсөнтэй холбоотой юм.

Бугат сумын ТТЗ-ийн 2016 оны нийт хөрөнгийн дүн 2720,3 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 27,2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь дотоод хяналт хэвийн гэж үзсэнтэй холбоотой юм.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 12 эрсдэлтэй асуудалд 12 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 22 хувь буюу 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой ОНХСангийн 9,6 сая төгрөгийн авлага, 11,8 сая төгрөгийн өглөгтэй холбоотой асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	0	0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	0	0,0	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

ОНХСангийн 2016 оны батлагдсан төсөвт аймгийн ОНХСангийн төсвөөс дутуу олгосон 9,6 сая төгрөгийн орлогын шилжүүлэгийг санхүүгийн тайланд санхүүжилтийн авлагаар тусгаж харуулаагүй, Мөн ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний дутуу олгогдсон 11,8 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийн өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй орхигдуулж нийтдээ 21,4 сая төгрөгийн алдаа зөрчил гаргаж Төсвийн тухай хуулийн 26.1 "Төсвийн байгууллага нь НББОУС болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтлөнө" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Албан шаардлага өгөгдөөгүй.

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сахилгын шийтгэл ногдуулах алдаа, зөрчил илэрээгүй.

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх алдаа, зөрчилтэй асуудал байхгүй байна.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

ОНХС, СХСангийн авлага, өглөгийн бүртгэл тооцоо, баталгаажуулалт

2.11 Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

1. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Данс ны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	<u>35766402.24</u>	<u>17168679.19</u>	<u>18597723.05</u>
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	35766402.24	17168679.19	18597723.05
31211	Төрийн сангийн харилцах	35747397.24	15966830.30	19780566.94
31213	Арилжааны банк дахь харилцах	19005.00	1201848.89	-1182843.89

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар оны эцэст нийтдээ 17,2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл нийт үлдэгдэл мөнгөний 1,2 сая төгрөг нь арилжааны банкин дахь, 15,9 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл байна. Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдлийн 15,4 сая төгрөг нь Орон нутгийн ерөнхий орлогын дансны, 0,5 сая төгрөг нь СХСангийн дансны үлдэгдэл байна.

Арилжаны банкинд байгаа 1201,8 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн дансны үлдэгдэл байна.

2. Авлагын бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
33	АВЛАГА	<u>240880380.00</u>	<u>222447607.00</u>	<u>18432773.00</u>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3409169.00	8408871.00	-4999702.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага		9600000.00	-9600000.00
335	Бусад авлага	640000.00	500000.00	140000.00
3351	Байгууллагаас авах авлага	640000.00		640000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага		500000.00	-500000.00
336	Зээлийн авлага	236831211.00	203938736.00	32892475.00

Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл өмнөх оноос 18,4 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Санхүүгийн албанаас сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын өмнөх оны үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, залруулга хийсэнтэй холбоотой үлдэгдэл оны эхнээс 32,9 сая төгрөгөөр буурсан байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тооцоо нийлж, зээлдэгч нэг бүрээр гарын үсэг зуруулж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

ОНХСангийн 2016 оны батлагдсан төсвөөс 9,6 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан боловч, санхүүгийн тайланд авлагаар харуулаагүй байсныг залруулга хийж авлагаар тусгуулав.

3. Бараа материалын бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
35	БАРАА МАТЕРИАЛ	33058177.00	32430855.00	627322.00
351	Түүхий эд материал	3725616.00	3854433.00	-128817.00
354	Хангамжийн материал	26545061.00	25788922.00	756139.00

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 6,2 сая төгрөгөөр буурсан байна. Бараа материалын бүтцийг авч үзвэл 11,7 хувь нь түүхий эд материал, 88,3 хувь нь хангамжийн материал байна. Тайлант онд нийтдээ 0,7 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

4. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2422304447.55	2457898609.59	-35594162.04
391	Газар			0.00
392	Биет хөрөнгө	2421811947.55	2457646526.30	-35834578.75
393	Биет бус хөрөнгө	492500.00	252083.29	240416.71

Үндсэн хөрөнгө оны эхнээс 35,6 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна. Тайлант онд 5,9 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 121,7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд 91,8 сая төгрөгийн элэгдэл тооцож, хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэл 1305,3 сая төгрөгт хүрсэн байна.

Төсөвт байгууллагууд нийтдээ 121,7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас ЭМТөв 31,5 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 90,2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгө оруулалтаар хүлээн авсан байна. Тайлант онд 11,9 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

5. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	22843520.00	11800000.00	11043520.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22843520.00	11800000.00	11043520.00
413	Өглөг	22843520.00	11800000.00	11043520.00
4136	Бусад өглөг	0.00	11800000.00	-11800000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		11800000.00	-11800000.00

Оны эхэнд Бүрэн дун дсурсууль 22,8 сая төгрөгийн богино хугацаат өглөгийн үлдэгдэлтэй байсныг тайланд онд бүрэн барагдуулж, оны эцэст өглөггүй гарсан байна. Бугат сумын ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний дутуу олгогдсон 11,8 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийн өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй орхигдуулсаныг аудитын явцад санхүүгийн тайланд тусгуулан залруулга хийлээ. Оны эцэст ОНХСангийн 11,8 сая төгрөгийн өглөгтэй байна.

6. Орлого, татаас санхүүжилтийн талаар

6.1 Улсын төсвийн санхүүжилт

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр нийтдээ 1392,2 сая төгрөгийн санхүүжилт, 14,1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

6.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Орон нутгийн захиргааны байгууллагуудад аймгийн төсвөөс 264,7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авч, орон нутгийн татварын орлогоос 78,9 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн санхүүжүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр 89,2 сая төгрөг хүлээн авчээ.

6.3 Өөрийн орлого

Бугат сумын төсөвт байгууллагуудад үндсэн үйл ажиллагааны орлогоос 760,0 мянган төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 242,5 мянган төгрөгийн орлого оруулсан байна.

6.4 Татварын орлого

Бугат сумын ИТХ-аас сумын 2016 оны Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 25,7 сая төгрөгөөр баталжээ. Орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогын 13,6 хувийг ХАОАТатвараас, 19,8 хувийг бусад татвараас, 8,9 хувийг өмчийн татвараас, 57,5 хувийг байгалийн нөөц ашигласны төлбөрөөс оруулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /төгрөг/

Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
Нийт орлогын дүн	25712300	64133933.06	38421633.1	249.4%
Татварын орлого	25712300	64133933.06	38421633.1	249.4%
ХАОАТатвар	3525000	8298453.06	4773453.1	235.4%
Өмчийн татвар	2337000	1731000	-606300	90.3%
Бусад татвар	5050000	9982700	4932700	197.7%
Байгалийн нөөц ашигласны төлбөр	14800000	43631780	28831780	294.8%
Татварын бус орлого	0.0	490000	192,000	

Гүйцэтгэлээр Орон нутгийн орлогод нийтдээ 64,1 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 38,4 сая төгрөгөөр буюу 149,4 хувиар давуулан биелүүлжээ. Нийт орлогын 12,9 хувийг ХАОАТатвараас, 2,6 хувийг өмчийн татвар 15,4 хувийг бусад татвар, 68 хувийг байгалийн нөөц ашигласны төлбөр, 0,8 хувийг татварын бус орлого бүрдүүлж байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатвар 4773,4 мянган төгрөгөөр буюу 134,5 хувиар, байгалийн нөөц ашигласны төлбөр 28831,7 мянган төгрөг буюу 194,8 хувиар, бусад татвар 4932,7 мянган төгрөгөөр буюу 97,7 хувиар тус тус давж биелсэн бол өмчийн татвар 606,3 мянган төгрөг буюу 9,7 хувиар тасарчээ. Байгалийн нөөц ашигласны төлбөрийг 28,8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь татварын орлогын төлөвлөгөө давж биелэгдэхэд гол нөлөө үзүүлжээ.

Орон нутгийн орлогын 995 тоот данс оны эхэнд 30,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 64,1 сая төгрөгийн татварын орлого оруулж оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 15,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Сумын төрийн сан дахь цалин хөлсний татварын орлогын 901 тоот дансаар нийтдээ 87912,9 мянган төгрөгийн орлогыг оруулж, аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Сумын төсөвт байгууллагуудаас төлсөн цалин хөлсний татварын орлогыг тухай бүр аймгийн ЦХТОрлогын дансанд төвлөрүүлж ажилласан байна.

Сумын татварын орлогын 995 тоот дансанд орсон газрын төлбөрийн 949,0 мянган төгрөгийг аймгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

6.5 Бусад

Тайланд онд ОНХСангийн санхүүжилтэнд 80,1 сая төгрөгийн санхүүжилт авч, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 3,9 сая төгрөгийг, Эргэлтийн эмийн санд 3,5 сая төгрөгийн орлого оруулсан байна.

7. Зарлага санхүүжилтийн талаар

7.1 Санхүүжилтийн зарцуулалт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Толбо сумын ТТЗ-ийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2016 оны урсгал зардалд нийтдээ 1816,5 сая төгрөгийн төсөв батлагдсаны 1392,2 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 333,9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 89,7 сая төгрөгийг ОНХСангийн хөрөнгөөр, 0,7 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 1391,9 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 343,7 сая төгрөгийн санхүүжилт, ОНХСангийн орлогын шилжүүлгээр 70,3 сая төгрөгийн санхүүжилтийг авч өөрийн үйл ажиллагааны орлогоос 0,2 сая төгрөг оруулан бүгд дүнгээр 1806,3 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж, батлагдсан төсвөөс нийт дүнгээр 10,2 сая төгрөгөөр бага зарлага гаргажээ.

Энэ нь ОНХСанд төсвөөс олгох санхүүжилт 9,6 сая төгрөгөөр дутуу олгогдсон болон өөрийн орлогын төлөвлөгөө 0,6 сая төгрөг тасарсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1816,5	1810,8	-0.32%	-5,7
1.1	Урсгал зардал	1816,5	1810,8	-0.32%	-5,7

1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр				
2.1	Улсын төсвөөс санхүүжих	1392,1	1391,9	-0,01%	-0,2
2.2	Орон нутгийн төсвөөс санхүүжих	423,6	414,1	-2,2%	-9,5
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	0,7	0,2	-250%	-0,5

Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал:

/төгрөг/

Төсөвт байгууллагуудын нэр	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
Сумын ИТХурал	37 722 800	37 722 800	0	100%
Сумын ЗДТГ азар	296 165 200	296 165 200		100%
Бүрэн дунд сургууль	775 534 600	775 534 600		100%
Эрүүл мэндийн төв	287 391 400	287 391 400		100%
Хүүхдийн цэцэрлэг	278 751 600	278 751 600		100%
Соёлын төв	51 206 200	50 539 900	666 300	98,6%
ОНХ сан	89 728 900	84 650 000	5 078 900	73,4%
Бүгд	1 816 500 700	1 810 755 500	5 745 200	94,3%

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэл: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал болон цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 15,6-8825,8 мянган төгрөгөөр хэтрүүлж, НДШимтгэл, нормативт зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэг, байр ашиглалттай холбоотой зардал, хангамж бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолтын зочны зардлуудыг 0,1- 6,9 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5000000.00	-5000000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1816500700.00	1810755500.00	5745200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1816500700.00	1810755500.00	5745200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1715112800.00	1709705000.00	5407800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1143842610.00	1152668451.00	-8825841.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127352300.00	120414349.00	6937951.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81614100.00	80960700.00	653400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36705000.00	36505470.00	199530.00

2105	Нормативт зардал	143754400.00	142443200.00	1311200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13202600.00	13202000.00	600.00
2107	Томилолт, зочны зардал	4687700.00	4672400.00	15300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32519900.00	32535500.00	-15600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	131434190.00	126302930.00	5131260.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101387900.00	101050500.00	337400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	101387900.00	101050500.00	337400.00

7.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийтдээ 102,6 сая төгрөгийн орлого хүлээн авч урсгал зардалд 102,6 сая төгрөгийг зарцуулсан байна. Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

7.3 Тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулалт

Бугат сумын 6 төсөвт байгууллага тусгай зориулалтын шилжүүлгээр 1392,2 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөгдсөнөөс 1391,9 сая төгрөгийн санхүүжилтийг авч 0,3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

7.4 Сангийн зарцуулалт

Бугат сумын ОНХСан нь оны эхэнд 5,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант онд 80,1 сая төгрөгийн санхүүжилт авч, 84,6 сая төгрөгийг сумын ИТХурлаас батлагдсан төсөл арга хэмжээнд зарцуулж, оны эцэст 0,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн харилцах данс оны эхэнд 0,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд эргэн төлөлтөөс 3,9 сая төгрөгийн орлогыг оруулсан ба тайлант онд 4,4 сая төгрөгийн зээл олгож оны эцэст үлдэгдэлгүй байна. СХСан нь жилийн эцэст 203,9 сая төгрөгийн зээлийн авлагатай байна.

Эргэлтийн эмийн сан оны эхэнд арилжааны банкин дахь харилцах дансандаа 19,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 3555,4 мянган төгрөгийн орлого оруулж, 2372,8 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 1201,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

8. Эзэмшигчийн өмчийн талаар

Бугат сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар эзэмшигчийн өмч 8,9 сая төгрөгөөр буурч 2718,1 сая төгрөг болсон байна. Үүнээс ЗГОКапитал 1374,6 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 724,2 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 619,3 сая төгрөг байна.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар тайлант онд 41,8 сая төгрөгийн үр дүнтэй ажиллаж, хуримтлагдсан үр дүн 619,3 сая төгрөг болж буурсан дүнтэй байна. Дахин үнэлгээний нөөц 724,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Бугат сумын ТТЗ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянав.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна. Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Бугат сумын Засаг даргын 2016.10.05-ны өдрийн 163 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар:

1. ОНХСан, СХСангийн санхүүгийн тайланг тус тусд нь гаргуулж санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэгтгэлд оруулж байх, СХСангийн зээлийн авлагын тооцооны үлдэгдлийг баталгаажуулж санхүүгийн тайланд авлагаар тусгаж байх.

2. Санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлийг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу дэлгэрэнгүй бэлтгэж ирүүлж байх гэсэн 2 заалт бүхий зөвлөмж өгөгдсөнийг тайлант онд хэрэгжүүлж ажилласан байна.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бугат сумын ТТЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бугат сумын ТТЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийг санхүүгийн тайнад залруулга хийсэн бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

2.15 Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар

